

ТОВЧ ХУРААНГУЙ

Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн үеийн мэс засал эмчилгээний үр дүнг судлах

Үндэслэл

Гурвалсан мэдрүүлийн өвдөлт /Trigeminal Neuralgia/ нь арван хоёр хос мэдрүүлийн V мэдрүүл буюу гурвалсан мэдрүүлийн салаанууд, хэт мэдрэмтгий, цочромтгой болсноор, гэнэт тодорхой дахилтат давтамжтай, хурц зүйлээр шөвөгдөж, хатгуулж, зүсүүлж буй, цахилгаанаар цохиулах мэт хүчтэй цоргисон өвдөлт өгдөг эмгэг юм.

Манай орны хувьд харьцангуй олон шалтгаантай элбэг тохиолдож буй нь клиник практикт ажиглагдсан билээ. Мөн гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн үеийн мэс заслын эмчилгээний талаар урд өмнө хийгдсэн шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнг тооцон гаргасан судалгаа, материал өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Манай оронд гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн мэс засал эмчилгээний арга барил нь бусад хөгжингүй улс орнуудад хийж буй арга барилаас харьцангуй хоцрогдсон байгаа учраас орчин үеийн багаж төхөөрөмжүүд ашиглан, мэс заслын шинэ аргыг бусад уламжлалт аргуудтай харьцуулж үзсэний үндсэн дээр сонголт хийж эмчилгээнд нэвтрүүлэх нь зүйтэй гэж бид үзлээ.

2007 оноос гурвалсан мэдрүүлийн өвдөлтйн үед гурвалсан мэдрүүлийн дарагдалыг чөлөөлөх мэс заслын шинэ аргаар мэс засал хийх болсон билээ. Энэхүү арга нь олон давуу талуудтай гэж бид үзэж байна.

- Мэс заслын дараа зовиур шууд арилах
- Мэс заслын дараа дахих магадлал бага
- Мэс заслын хүрээ багасч, үлдэх шарх нь бага
- Мэс заслын дараа эдгэрэлт хурдан явагдана

Бидний боловсруулсан арга нь дээрх давуу талуудтай боловч мэс засал нь микро түвшинд явагддагтай холбоотой мэс заслын үед болон мэс заслын дараах

хүндрэл, ерөнхий унтуулга дор хийгдсэнтэй холбоотой бие эрхтэний талаас хоёрдогч хүндрэлүүд гарах болон эмчилгээний зардал өндөр зэрэг дутагдалтай талууд байгааг бид бодолцож байгаа. Цаашид бид гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн үед тохирсон мэс заслын эмчилгээний арга барилийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоох нь чухал гэж бид үзсэн юм.

Зорилго

Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн /ГМӨ/ үеийн мэс засал эмчилгээний үр дүнг судлан, өөрийн улсын клиникийн нөхцөлд хийгдэх бололцоотой мэс засал эмчилгээний аргыг сонгон нэвтрүүлэхэд судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт

1. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн мэс заслын заалтыг тодорхой болгох
2. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн тохиолдол болон эмнэлзүйг тодорхойлох
3. Мэс заслын эмчилгээний аргуудын үр дүнг харьцуулан судлан, эмчилгээний үр дүн сайтай аргыг сонгох

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгааг 2007 – 2010 оны хооронд Шастины Төв Эмнэлэгийн Мэдрэлийн Мэс Заслын тасагт хандсан 48-72 насны хүнийг, нас, хүйс, ажил мэргэжил харгалзахгүй хамруулан хийсэн.

Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийг зовиур, асуумж, бодит үзлэг, компьютер томографи болон соронзон долгионт томографийн шинжилгээний тусламжтай тодорхойлсон. Судалгаа хийсэн үнэлгээ, дүгнэлтийн хэсэгтээ SPSS-11 программыг ашиглан статистик боловсруулалтыг тус тус хийлээ.

Үр дүн

Бид гурвалсан мэдрүүлийн судасны дарагдалыг чөлөөлөх мэс засал болон бусад мэс заслын эмчилгээний аргаар эмчилгээ хийлгэсэн өвчтөний эдгэрэлтийн байдлыг судалгаанд хамрагдсан нийт өвчтөнөөс асуумж судалгааны картаар авсан баримтанд тулгуурлан харьцуулан тогтоосон юм. Асуумж судалгаанаас аргуудын ололттой болон дутагдалтай талуудыг тодотгож өгөх үүднээс өвчний төгсгөлтэй шууд холбоотой асуултуудыг сонгон авч харьцуулалт хийлээ.

Бид гурвалсан мэдрүүлийн захын хориг, ГМ-ийн зангилааг таслах, ГМ-ийг хэсэгчилж таслах болон ГМ-ийн судасны дарагдалыг чөлөөлөх аргаар мэс засал эмчилгээ хийсэн нийт өвчтөний өвчний төгсгөлийг харьцуулж статистик харьцуулалт хийж, Стьюдентийн шинжүүрээр шинжиж үзэхэд гурвалсан мэдрүүлийн судасны дарагдалыг чөлөөлөх мэс засал эмчилгээний арга нь бусад мэс засал эмчилгээний аргуудаас илүү үр дүнтэй болох нь статистик үнэн магадлалын $P < 0.001$ -ийн түвшинд батлагдаж байлаа. Дээрхи дүн нь өвчтөнийг эмнэлгээс гарах үеийн үзлэгийн дүн бөгөөд өвчтөн эмнэлгээс гарсны дараа 1-4 жилийн хугацаанд эмчийн хяналтанд байсан.

Барров Мэдрэлийн Хүрээлэнгийн үнэлгээний (Barrow Neurological Institute scoring system BNI) системийн дагуу хийсэн үнэлгээгээр гурвалсан мэдрүүлийн судасны дарагдалыг чөлөөлөх мэс заслын сайн үр дүн нь 89.37% эдгэрэлттэй, хүндрэл болон дахилт бага байсан бол гурвалсан мэдрүүлийн захын хориг, гурвалсан мэдрүүлийн зангилааг таслах аргаар хийсэн эмчилгээний сайн үр дүн нь 25.9% тай байв.

Мөн гурвалсан мэдрүүлийн захын хориг, зангилааг таслах, хэсэгчилж таслах мэс засал эмчилгээний аргуудаас гурвалсан мэдрүүлийн дарагдалыг чөлөөлөх аргаар мэс засал хийсэн өвчтөнүүдийн эдгэрэлтийн байдлыг харьцуулж үзэхэд гурвалсан мэдрүүлийн судасны дарагдлыг чөлөөлөх мэс заслын аргаар хийсэн өвчтөнүүдийн эдгэрсэн байдал нь бусад аргаар эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийнхээс илүү үр дүнтэй байгааг харуулж байна. ($t=4.47$, $P < 0.01$)

Дүгнэлт

1. Гурвалсан мэдрүүлийн өвдөлт нь манай орны нөхцөлд жилд 15-20 тохиолдол илэрч байгаа бөгөөд өвчтөнд шаналгаатай эмийн эмчилгээнд бүрэн эдгэрэх боломжгүй тохиолдолд мэс засал эмчилгээ хийх шаардлагтай эмгэг болох нь тогтоогдлоо.
2. Судасны шалтгаантай гурвалсан мэдрүүлийн өвдөлт нь манай оронд 50-аас дээш насныханд тохиолдож байгаа бөгөөд гол төлөв зүүн талын (55%) гурвалсан мэдрүүлийн хоншоорын салаа (40.9%), эрүүний салааг (27.2%) хамарсан байна.
3. Гурвалсан мэдрүүлийн дарагдсан ширхэгийг чөлөөлөх аргаар эмчлэх мэс заслын арга нь гурвалсан мэдрүүлийн бусад захын хориг хийлгэх, зангилааг таслах аргуудаас эдгэрэлт өндөр давуу талтай, үр дүнтэй (89.37%) эмчилгээний арга болох нь судалгаанаас харагдаж байна.

Түлхүүр үг

Гурвалсан мэдрүүлийн өвдөлт, гурвалсан мэдрүүлийн дарагдлыг чөлөөлөх, мэдрэлийн мэс засал, мэс засал эмчилгээ

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	9
НЭГ. УДИРТГАЛ	
1.1. Судалгааны үндэслэл	10
1.2. Судалгааны зорилго	12
1.3. Судалгааны зорилт	12
1.4. Судалгааны шинэлэг тал	12
1.5. Хамгаалахаар практик ач холбогдол	12
1.6. Судалгааны дэвшүүлж буй асуудлууд	13
1.7. Судалгааны ёс зүйн асуудал	13
1.8. Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал	14
1.9. Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал	14
ХОЁР. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	
2.1. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн тархалт	16
2.2. Гурвалсан мэдрүүлийн өвдөлт	17
2.3. Гурвалсан мэдрүүлийн бүтэц, мэдрэлжүүлэлт	19
2.4. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн шалтгаан ба эмгэг жам	21
2.5. Эмнэлзүй	23
2.6. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн оношлогоо	25
2.7. Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн мэс засал эмчилгээний аргууд, тэдгээрийн үр дүн	26
2.8. Гурвалсан мэдрүүлийн судасны дарагдалыг чөлөөлөх мэс заслын эмчилгээний арга	28

2.9.	Гурвалсан мэдрүүлийн дарагдалыг чөлөөлөх мэс заслын эмчилгээний үед гарч болох хүндрэлүүд	28
ГУРАВ.	СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	
3.1.	Судалгааны загвар	30
3.2.	Судалгааны хүрээ ба түүвэр	30
3.3.	Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн	30
3.4.	Судалгааны материал цуглуулсан аргууд	31
3.5.	Судалгааг хийсэн аргачилал	32
3.6.	Гурвалсан мэдрүүлийн өвдөлтийн мэс заслын эмчилгээний аргууд	34
ДӨРӨВ.	СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН	39
ТАВ.	СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЦЭМЖ	51
ЗУРГАА.	СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ	
6.1.	Дүгнэлт	57
6.2.	Зөвлөмж	57
ТАЛАРХАЛ		58
НОМ ЗҮЙ		
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭВЛҮҮЛСЭН БҮТЭЭЛҮҮД		
	Эрдэм шинжилгээний өгүүлэл	
	Зөвшөөрлийн хуудас	